**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/33 Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх хавсралтаар заасан төсөл, арга хэмжээнүүдийг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

8200019073

8200010043

Аймгийн Засаг даргын 2026 оны
01 дүгээр сарын 09-ны өдрийн А/23 дугаар
захирамжийн хавсралт

## АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2026 ОНД САНХҮҮЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Хугацаа | | Төсөвт өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | |
| 1. | Түмэн багийн гэр хорооллын ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажил | 2026 | 2026 | 19,900,000 |
| 2. | Жишиг хашааны зураг төсөл боловсруулах ажил | 2026 | 2026 | 10,000,000 |
| 3. | Бигэр сумын сургууль, цэцэрлэг, спорт заалны барилгыг дулаан хангамжид холбох ажлын зураг төсөл боловсруулах ажил | 2026 | 2026 | 20,000,000 |
| 4. | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээний өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах ажил | 2026 | 2026 | 19,990,000 |
| 5. | Номын сангийн барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах ажил | 2026 | 2026 | 19,000,000 |

__oOo__